



МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА САНДАГИЙН  
БЯМБАЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06.18 № ЗГ-1/70

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001461



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.18 № МЭГ/2160

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай**

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 64 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265007136

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“17.ХЭЛЭЛЦСЭН нь: Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.**  
**МОНГОЛ УЛСЫН**  
**ТЭРГҮҮН ШАДАР САЙД**  
**БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,**  
**ХӨГЖЛИЙН САЙД**

**Ж.ЭНХБАЯР**

**БАТЛАВ.**  
**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС**  
**БАЯЛГИЙН САЙД**

**Г.ДАМДИННЯМ**

**БАТЛАВ.**  
**САНГИЙН САЙД**

**З.МЭНДСАЙХАН**

**БАТЛАВ.**  
**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,**  
**НИЙГМИЙН**  
**ХАМГААЛЛЫН САЙД**

**Т.АУБАКИР**

**БАТЛАВ.**  
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД**  
**ХЭРГИЙН САЙД**

**С.АМАРСАЙХАН**

2026 оны 06 дугаар сарын 16-ний өдөр

## **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ** **ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл, боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.3-т “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 3.3-т “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.”, “3.3.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулж, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих”, “3.3.2. Газрын тосны ашиглалтын баталгаат нөөцийг өсгөж, газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах дамжуулах хоолойг барьж байгуулах” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 3-т “11. Газрын тос боловсруулах төслүүд /Газрын тосны нөөц хайгуулын төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, дагалдах барилга байгууламжийн төсөл/” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега

төслийн 12-т “Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.” гэж, 3.3.1.6-д “Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах үндэслэл болж байна.

## **1.2.Практик шаардлага**

Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилтын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, бүтээгдэхүүн хуваалтаас Засгийн газарт ногдох тосны орлого болон татвар, төлбөрийг давхардуулахгүй байх замаар хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинэ ордуудыг илрүүлэх, нөөцийг өсгөх, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд БХГ-ний дагуу газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хөрөнгө оруулалт, олборлолт буурч байгаа бөгөөд гол шалтгаан нь татвар, нийгмийн даатгал, аудит болон бусад хууль, эрх зүйн тогтворгүй байдал, орон нутгийн эсэргүүцэл зэрэг нөлөөлж байна.

Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн дагуу 1993, 1995, 1997 онуудад байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд нь татварын багц хууль болон бусад хууль тогтоомжуудын өөрчлөлттэй зөрчилдөж эхэлснээр татварын асуудалтай тулгарч байна.

Тухайлбал, “Петрочайна Дачин Тамсаг” компанийн хувьд 2013-2024 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 703.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан бол 2013-2020 оныг хамарсан нийгмийн даатгалд нийт 7.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан байна. Мөн холбогдох татварын хуулийн өөрчлөлтийн хүрээнд 2013 оноос 2014 оны Газрын тосны тухай хуулийг дагалдан өөрчлөлт орох хүртэлх хугацаанд хилээр оруулсан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, бараа материалд гаалийн тариф, НӨАТ болох 22.2 тэрбум төгрөг (16.6 сая ам.доллар)-ийг төлсөн. Мөн Тосон-Уул XIX талбайн БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.1-д роялти буюу газрын тосны нөөц ашигласны төлбөр нь Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэсэгт багтахгаар заасан бөгөөд 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуульд өмнө байгуулагдсан БХГ-үүдийн төлбөр, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтын хувь хэмжээг гэрээнд заасан хувь хэмжээгээр зохицуулахаар тус тус заасан. Гэвч Үндэсний аудитын газраас Тосон-Уул XIX талбайн 2014-2018 оныг хамарсан аудитаар газрын тосны нөөц ашигласны төлбөр 66.7 тэрбум төгрөгийг нөхөн төлөх акт тавьсан.

“Доншен газрын тос (Монгол)” компанийн хувьд мөн адил шалтгаанаар 2012-2023 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 23.8 тэрбум төгрөгийн акт тавигдсан. Мөн түүхий тос хуваалтын экспортын цэгтэй холбоотой зардлын ангиллын

маргаанаас үүдэлтэйгээр Үндэсний аудитын газраас 2014-2022 оныг хамрах хугацаанд хооронд 12.4 тэрбум төгрөгийн албан шаардлага, акт тавьсан бөгөөд цаашид жил бүр энэ төлбөр нэмэгдэн гарахаар байна.

Мөн Дорнод аймгийн Аудитын газраас Ашигт малтмалын тухай хуулийг үндэслэн “Петрочайна Дачин Тамсаг” компанийг гадаад ажилтны квот хэтрүүлсэн шалтгаанаар 5.3 тэрбум төгрөг нөхөн төлүүлэх акт тавьсан бол Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас Бичигт боомт руу түүхий тос тээвэрлэж байгаль орчинд хохирол учруулсан гэж үзэж 21.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаад байна. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын Засаг даргатай байгуулахаар Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17-д заасныг үндэслэн Дорнод аймгийн Халх гол, Матад сумдаас нийт 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг нэхэмжилсэн.

Эдгээр нөхцөл шалтгаанаас хамааран газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын дансыг битүүмжилж, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж, улмаар ус, цахилгааны төлбөр, хураамж болон ажилчдын цалин хөлс, хангамж, туслан гүйцэтгэгчдийн төлбөрийг төлөх боломжгүй болох нөхцөл үүссээр байна.

“Петрочайна Дачин Тамсаг ХХК” нь БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд нийт 4.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 1.8 тэрбум ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 2.5 тэрбум ам.долларыг нөхөж авах дутуу байна. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хувьд 1997 оны бүтэгдэхүүн хуваах гэрээт талбайд нийт 350.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 194.0 сая ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 156.2 сая ам.долларыг нөхөж авах дутуу байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгч нь холбогдох татваруудаас чөлөөлөгдөх бөгөөд хэрэв Засгийн газрын аль нэг байгууллагаас шаардсаны дагуу төлсөн тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нөхөн төлөхөөр зохицуулсан.

Дээрх 2 компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаанд нийт 12 сая тонн газрын тос олборлож, 11.5 сая тонн газрын тос экспортолсон бөгөөд бүтээгдэхүүн хуваалтаар улсын төсөвт нийт 3 их наяд төгрөгийг төвлөрүүлээд байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2023 онд 304.2 тэрбум төгрөг, 2024 онд 237.9 тэрбум төгрөг, 2025 онд 231.9 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2026 оны төсвийн хуулиар 231.5 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний суурь зарчмын дагуу татвар, бүтээгдэхүүн хуваалтын орлого хоёрыг давхардуулахгүйгээр нэгэнт үүссэн актуудын төлбөрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, холбогдох татвар, шимтгэл, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газрын үүргийн дагуу үе шаттайгаар Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцох замаар шийдвэрлэх зорилгоор Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн

даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай болон тэдгээрийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлийг тогтвортой хадгалах, тухайн гэрээнд заасан татвар, шимтгэл, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг олон улсын гэрээтэй адилтган гэрээний дагуу хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхой болгоход оршино.

Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулна:

- 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд мөрдөх холбогдох татвар, төлбөр, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг тодорхой болгох;
- шинэчилсэн Газрын тосны тухай хуулийн зарим зохицуулалт өмнөх гэрээнд шууд үйлчлэхгүй байх эрх зүйн үндсийг тогтоох;
- бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн татвар, нийгмийн даатгал болон аудитын актын төлбөрийг Засгийн газрын хүлээсэн үүргийн хүрээнд зохицуулах;
- төрийн байгууллага болон гэрээлэгчийн хоорондын эрх, үүргийн хэрэгжилтийг тодорхой болгох;
- өмнө байгуулсан гэрээний тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

### **Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Энэ хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн эерэг үр дагаврыг бий болгоно:

1/Өмнө байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн эрх зүйн орчны тодорхой, тогтвортой байдлыг хангана;

2/Хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын орчин тогтворжино;

3/Татвар, шимтгэл, төлбөртэй холбоотой асуудлыг нэгдсэн байдлаар зохицуулна;

4/Газрын тосны салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдана;

5/Төр болон хөрөнгө оруулагчийн хоорондын маргаан буурна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт шууд нэмэлт зардал үүсгэхгүй бөгөөд бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн төлбөр, тооцоог гэрээний нөхцөлд нийцүүлэн үе шаттайгаар зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”, 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, газрын тос боловсруулах үйлдвэр, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах, нефть-химийн үйлдвэр байгуулах, газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахаар тусгасан.

Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилтын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинэ ордуудыг илрүүлэх, нөөцийг өсгөх, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд БХГ-ний дагуу газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хөрөнгө оруулалт, олборлолт буурч байгаа бөгөөд гол шалтгаан нь татвар, нийгмийн даатгал, аудит болон бусад хууль, эрх зүйн тогтворгүй байдал, орон нутгийн эсэргүүцэл зэрэг нөлөөлж байна.

Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн дагуу 1993, 1995, 1997 онуудад байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд нь татварын багц хууль болон бусад хууль тогтоомжуудын өөрчлөлттэй зөрчилдөж эхэлснээр татварын асуудалтай тулгарч байна.

Тухайлбал, “Петрочайна Дачин Тамсаг” компанийн хувьд 2013-2024 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 703.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан бол 2013-2020 оныг хамарсан нийгмийн даатгалд нийт 7.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан. Мөн холбогдох татварын хуулийн өөрчлөлтийн хүрээнд хүрээнд 2014 оны Газрын тосны тухай хуулийг дагалдан өөрчлөлт орох хүртэлх хугацаанд хилээр оруулсан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, бараа материалд гаалийн тариф, НӨАТ болох 22.2 тэрбум төгрөг (16.6 сая ам.доллар)-ийг төлсөн. Тосон-Уул XIX талбайн БХГ-ний 8 дугаар зүйлийн 8.1-д роялти буюу газрын тосны нөөц ашигласны төлбөр нь Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэсэгт багтахар заасан бөгөөд 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуульд өмнө байгуулагдсан БХГ-үүдийн төлбөр, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтын хувь хэмжээг гэрээнд заасан хувь хэмжээгээр зохицуулахаар тус тус заасан. Гэвч Үндэсний аудитын газраас Тосон-Уул XIX талбайн 2014-2018 оныг хамарсан газрын тосны нөөц ашигласны төлбөр 66.7 тэрбум төгрөгийг нөхөн төлөх акт тавьсан.

“Доншен газрын тос (Монгол)” компанийн хувьд мөн адил шалтгаанаар 2012-2023 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 23.8 тэрбум төгрөгийн акт тавьсан. Мөн түүхий тос хуваалтын экспортын цэгтэй холбоотой зардлын ангиллын маргаанаас үүдэлтэйгээр Үндэсний аудитын газраас 2014-2022 оны хооронд 12.4 тэрбум төгрөгийн албан шаардлага, акт тавьсан бөгөөд цаашид жил бүр энэ төлбөр нэмэгдэн гарахаар байна.

Мөн Дорнод аймгийн Аудитын газраас Ашигт малтмалын тухай хуулийг үндэслэн “Петрочайна Дачин Тамсаг” компанийг гадаад ажилтны квот хэтрүүлсэн шалтгаанаар 5.3 тэрбум төгрөг нөхөн төлүүлэх акт тавьсан бол Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас Бичигт боомт руу түүхий тос тээвэрлэж байгаль орчинд хохирол учруулсан гэж үзэж 21.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаад байна. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумтай байгуулахаар Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17-д заасныг үндэслэн Дорнод аймгийн Халх гол, Матад сумдаас нийт 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг нэхэмжилсэн.

Эдгээр нөхцөл шалтгаанаас хамааран газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын дансыг битүүмжилж, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж, улмаар ус, цахилгааны төлбөр, хураамж болон ажилчдын цалин хөлс, хангамж, туслан гүйцэтгэгчдийн төлбөрийг төлөх боломжгүй болох нөхцөл үүссээр байна.

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд нийт 4.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 1.8 тэрбум ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 2.5 тэрбум ам.долларыг нөхөж авах дутуу байна. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хувьд 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд нийт 350.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 194.0 сая ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 156.2 сая ам.долларыг нөхөж авах дутуу байна.

Дээрх 2 компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаанд нийт 12 сая тонн газрын тос олборлож, 11.5 сая тонн газрын тос экспортолсон бөгөөд бүтээгдэхүүн хуваалтаар улсын төсөвт нийт 3 их наяд төгрөгийг төвлөрүүлээд байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгч нь холбогдох татваруудаас чөлөөлөгдөх бөгөөд хэрэв Засгийн газрын аль нэг байгууллагаас шаардсаны дагуу төлсөн тохиолдолд Монгол Улсын Засгийн газар нөхөн төлөхөөр зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлийг тогтвортой хадгалж, тухайн гэрээнд заасан татвар, шимтгэл, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг гэрээний дагуу хэрэгжүүлэх эрх зүйн үндэс тодорхой болно.

Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулсан зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

- 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд мөрдөх татвар, төлбөр, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг тодорхой болгох;
- шинэчилсэн Газрын тосны тухай хуулийн зарим зохицуулалт өмнөх гэрээнд шууд үйлчлэхгүй байх эрх зүйн үндсийг тогтоох;
- бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн төлбөр, татвар, нийгмийн даатгал болон актын төлбөрийг Засгийн газрын хүлээсэн үүргийн хүрээнд зохицуулах;
- өмнө байгуулсан гэрээний тогтвортой байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

Иймээс газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй дээрх 2 компаниудад хяналт шалгалтаар тогтоогдсон Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдсэнээс бусад нийгмийн даатгал, татвар, актын төлбөрийг тухайн

бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газрын үүргийн дагуу үе шаттайгаар Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт тухай бүр суутган тооцох замаар нөхөн төлсөнд тооцох, цаашид нөөц ашигласны төлбөр, татвар, шимтгэлийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан болно.

---o0o---

## **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.16, 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.3, 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 12 болон 3.3.1.6 зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, газрын тос боловсруулах үйлдвэр, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах, нефть-химийн үйлдвэр байгуулах, газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахаар тусгасан.

Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулах, газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилтын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, шинэ ордуудыг илрүүлэх, нөөцийг өсгөх, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдахдаа түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль боловсруулж батлаагүйгээс тус хуулиас өмнө байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайд татвар, шимтгэл, төлбөрийн асуудлууд шилжилтийн үеийн зохицуулалтгүй үлдсэн.

Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК болон Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хөрөнгө оруулалт, олборлолт буурч байгаа бөгөөд гол шалтгаан нь татвар, нийгмийн даатгал, аудит болон бусад хууль, эрх зүйн тогтворгүй байдал, орон нутгийн эсэргүүцэл зэрэг нөлөөлж байна.

Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн дагуу 1993, 1995, 1997 онуудад байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд нь татварын багц хууль болон бусад хууль тогтоомжуудын өөрчлөлттэй зөрчилдөж эхэлснээр татварын асуудалтай тулгарч байна.

Тухайлбал, “Петрочайна Дачин Тамсаг” компанийн хувьд 2013-2024 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 703.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан бол 2013-2020 оныг хамарсан нийгмийн даатгалд нийт 7.3 тэрбум төгрөгийн акт тавигдсан. Мөн холбогдох татварын хуулийн өөрчлөлтийн хүрээнд хүрээнд 2014 оны Газрын тосны тухай хуулийг дагалдан өөрчлөлт орох хүртэлх хугацаанд хилээр оруулсан тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, бараа материалд гаалийн тариф, НӨАТ болох 22.1 тэрбум төгрөг (16.6 сая ам.доллар)-ийг төлсөн. Тосон-Уул XIX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 дугаар зүйлийн 8.1-д роялти буюу газрын тосны нөөц ашигласны төлбөр нь Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэсэгт багтахар заасан бөгөөд 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуульд өмнө байгуулагдсан БХГ-үүдийн төлбөр, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтын хувь хэмжээг гэрээнд заасан хувь хэмжээгээр зохицуулахаар тус тус заасан. Гэвч Үндэсний аудитын газраас Тосон-Уул XIX талбайн 2014-2018 оныг

хамарсан газрын тосны нөөц ашигласны төлбөр 66.7 тэрбум төгрөгийг нөхөн төлөх албан шаардлага тавьсан.

“Доншен газрын тос (Монгол)” компанийн хувьд мөн адил шалтгаанаар 2012-2023 оныг хамарсан татварын хяналт шалгалтаар нийт 23.8 тэрбум төгрөгийн акт тавьсан. Мөн түүхий тос хуваалтын экспортын цэгтэй холбоотой зардлын ангиллын маргаанаас үүдэлтэйгээр Үндэсний аудитын газраас 2014-2022 оны хооронд 12.4 тэрбум төгрөгийн албан шаардлага, акт тавьсан бөгөөд цаашид жил бүр энэ төлбөр нэмэгдэн гарахаар байна.

Мөн Дорнод аймгийн Аудитын газраас Ашигт малтмалын тухай хуулийг үндэслэн “Петрочайна Дачин Тамсаг” компанийг гадаад ажилтны квот хэтрүүлсэн шалтгаанаар 5.3 тэрбум төгрөг нөхөн төлүүлэх акт тавьсан бол Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас Бичигт боомт руу түүхий тос тээвэрлэж байгаль орчинд хохирол учруулсан гэж үзэж 21.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаад байна. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумтай байгуулахаар Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.17-д заасныг үндэслэн Дорнод аймгийн Халх гол, Матад сумдаас нийт 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг нэхэмжилсэн.

Эдгээр нөхцөл шалтгаанаас хамааран газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын дансыг битүүмжилж, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж, улмаар ус, цахилгааны төлбөр, хураамж болон ажилчдын цалин хөлс, хангамж, туслан гүйцэтгэгчдийн төлбөрийг төлөх боломжгүй болох нөхцөл үүссээр байна.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдсанаар Засгийн газраас БХГ-ний загварыг 2015 онд баталж, 2016-2018 онуудад эдгээр компаниудын гэрээнээс бусад БХГ-үүдийг хууль, загвар гэрээнд нийцүүлэн шинэчилсэн. Холбогдох яам, агентлагийн түвшинд энэхүү 2 компанитай гэрээг шинэчлэх талаар удаа дараа хэлэлцээр хийсэн боловч компаниудын зүгээс гэрээг өөрчлөхгүй, хэвээр хадгалах хатуу байр суурийг барьсаар байсан тул үр дүнд хүрээгүй.

Улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар 2022-2026 онуудад Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд зэрэг Засгийн газрын гишүүдээр ахлуулсан 6 ажлын хэсгийг байгуулан ажилласан бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийн түвшинд БНХАУ-д эдгээр компаниудын толгой компаниудын ТУЗ-ын дарга, Ерөнхийлөгч болон бусад албаны хүмүүс, удирдлагуудтай удаа дараа уулзалт хийсэн боловч гэрээлэгч компаниудын зүгээс БХГ-ээг хэвээр хадгалах хатуу байр суурийг барьсаар ирсэн ба үүссэн татвар, шимтгэл, төлбөрийн асуудлыг шийдвэрлэж өгөхийг удаа дараа мэдэгдсээр ирсэн.

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд нийт 4.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 1.8 тэрбум ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 2.5 тэрбум ам.долларыг нөхөж авах дутуу байна. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн хувьд 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд нийт 350.1 сая ам.долларын хөрөнгө оруулалт (өртөг нөхөгдөх зардал) хийснээс 194.0 сая ам.долларыг өртөгт газрын тосоор нөхөн авч, 156.2 сая ам.долларыг нөхөж авах дутуу байна.

Дээрх 2 компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаанд нийт 12 сая тонн газрын тос олборлож, 11.5 сая тонн газрын тос экспортолсон бөгөөд бүтээгдэхүүн хуваалтаар улсын төсөвт нийт 3 их наяд төгрөгийг төвлөрүүлээд байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгч болон гадаадын оролцон гүйцэтгэгч нь холбогдох татваруудаас чөлөөлөгдөх, мөн тэдгээрийн гадаад ажиллагсад орлогын татвар, нийгмийн даатгал болон бусад бүх татвараас чөлөөлөгдөх бөгөөд хэрэв Засгийн газрын аль нэг байгууллагаас татвар төлөхийг шаардаж төлөх ёстой гэж үзвэл, төлсөн баримтыг авчирмагц Монгол Улсын Засгийн газар нөхөн төлөхөөр зохицуулсан.

Иймээс газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй дээрх 2 компаниудад тулгамдаж буй Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдсэнээс бусад төлбөр, татвар, шимтгэлийн асуудлыг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дараах байдлаар зохицуулахаар Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

- Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, шимтгэл, актын төлбөрийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт тухай бүр суутган тооцох замаар нөхөн төлсөнд тооцох,
- Цаашид дээрх бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой нөөц ашигласны төлбөр, татвар, шимтгэлийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу зохицуулахаар тус тус тусгасан.

---o0o---

## **ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА**

### **1. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай:**

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 1991 оны Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдтэй холбоотой үүссэн татвар, шимтгэл, аудитын акт болон нөөц ашигласны төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх шилжилтийн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүссэн.

Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй компаниудад татвар, аудит, нийгмийн даатгал болон бусад байгууллагаас их хэмжээний акт, төлбөр ногдуулсан бөгөөд эдгээр асуудал нь бүтээгдэхүүн хуваах гэрээний заалттай холбоотой маргаан дагуулж байна. Түүнчлэн Тосон-Уул XIX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд газрын тосны нөөц ашигласны төлбөрийг Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэсэгт багтаан тооцохоор заасан боловч уг асуудлаар төлбөрийн маргаан үүссэн.

Иймд энэхүү хуулийн төслөөр бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, шимтгэл болон актын төлбөрийг Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцох, Тосон-Уул XIX талбайн нөөц ашигласны төлбөртэй холбоотой асуудлыг гэрээний нөхцөлийн дагуу шийдвэрлэх, цаашид уг төлбөрийг Засгийн газарт ногдох ашигт газрын тосны хэсэгт багтаан тооцох зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар өмнө үүссэн эрх зүйн маргаантай асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэж, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн эрх зүйн орчны тодорхой, тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой.

### **2. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай:**

Газрын тосны тухай 1991 онд батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд холбогдох татваруудаас чөлөөлөгдөхөөр зохицуулсан боловч татварын хуулиудын шинэчлэл, нэмэлт, өөрчлөлтүүдтэй зөрчилдөж эхэлснээр татварын маргаан үүсгэсээр байна.

Үүний улмаас газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй компанидад татварын хяналт шалгалтын дүнд их хэмжээний акт тогтоогдож, маргаан үүссэн бөгөөд энэ нь газрын тосны хөрөнгө оруулалт, олборлолтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байна.

Иймд хуулийн төслөөр Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг олон улсын гэрээтэй адилтган холбогдох татварыг тухайн гэрээнд заасны дагуу зохицуулах эрх зүйн үндсийг Татварын ерөнхий хуульд тусгахаар боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд хэрэгжих татварын зохицуулалт илүү тодорхой болж, хөрөнгө оруулагчдын эрх зүйн

итгэлцэл нэмэгдэн, газрын тосны салбарын үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдах үр нөлөөтэй.

### **3.Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай:**

Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотойгоор өмнө үүссэн татварын акт, төлбөрийг шийдвэрлэх шилжилтийн зохицуулалтыг тусгайлан тогтоох шаардлага үүссэн.

Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөл болон тухайн үеэс хойш шинэчлэн батлагдсан татварын хууль тогтоомжийн хооронд үүссэн маргаанаас шалтгаалан гэрээлэгч компаниудад татварын өр төлбөр, акт ногдуулсан асуудал бий болсон. Энэхүү асуудал нь зөвхөн татварын маргаан төдийгүй газрын тосны олборлолтын үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрээд байна.

Иймээс хуулийн төслөөр бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татварын актын төлбөрийг тухайн гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцох шилжилтийн зохицуулалтыг бий болгож, өмнө үүссэн асуудлыг гэрээний нөхцөлийн хүрээнд шийдвэрлэхээр тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар үүсээд байгаа татварын маргааныг шийдвэрлэх, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

### **4.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай:**

Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгч болон оролцон гүйцэтгэгчийн гадаадын ажилтнуудыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зохицуулалт тусгагдсан байдаг. Гэвч нийгмийн даатгалын хуулиудын шинэчлэл, өөрчлөлтүүдтэй зөрчилдөж, гадаад ажилчдын шимтгэлтэй холбоотой акт, төлбөр ногдуулах нөхцөл бий болсон.

Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний тогтвортой байдлыг алдагдуулах, хөрөнгө оруулагчдын эрх зүйн баталгаанд нөлөөлөх эрсдэл дагуулж байгаа тул гэрээнд тусгагдсан зохицуулалтыг хууль тогтоомжтой уялдуулах шаардлага үүссэн.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулж, Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх харилцааг тухайн гэрээний дагуу зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн тогтвортой байдал хангагдаж, хөрөнгө оруулалтын орчны эрх зүйн тодорхой байдал сайжрах юм.

### **5.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай:**

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд өмнө үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн актын асуудлыг шийдвэрлэх шилжилтийн зохицуулалт тогтоох шаардлага үүссэн.

Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчийн гадаад ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой акт ногдуулсан бөгөөд эдгээр нь гэрээний нөхцөл болон хүчин төгөлдөр хууль тогтоомжийн зохицуулалтын ялгаатай байдлаас үүдэлтэй юм.

Иймээс энэхүү хуулийн төслөөр бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн актын төлбөрийг тухайн гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцох замаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар өмнө үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэс бүрдэж, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой юм.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.” гэснийг “хуваалт болон татвар, шимтгэлийг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулна” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, шимтгэл, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

**2 дугаар зүйл.** Тосон-Уул XIX талбайн нөөц ашигласны төлбөртэй холбоотой үүссэн асуудлыг бүтээгдэхүүн хуваах гэрээний 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан тооцно.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг цаашид бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох хэсэгт багтаан нийт газрын тосны 5 хувиар тооцно.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.4 дэх хэсэг нэмсүгэй:

“46.4.Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх харилцааг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн нийгмийн даатгалын шимтгэл, актын төлбөрийг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт тухай бүр суутган тооцно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 4.1.3 дахь заалт нэмсүгэй:

“4.1.3.Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг олон улсын гэрээтэй адилтган холбогдох татварыг тухайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үүссэн татвар, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг